



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/57

Алтанбулаг

“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөнийг зохион
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 Монгол улсын Ерөнхийлөгчийн 2022 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 58 тоот зарлиг, Засгийн газрын 2022 оны “Тэр бум мод үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 350 тоот тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 131 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд зохион байгуулагдах “Тэр бум мод” зөвлөгөөний 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсугай.

2.Сумын хэмжээнд зохион байгуулагдах “Тэр бум мод” зөвлөгөөний зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дугаар хавсралт, “Тэр бум мод” зөвлөгөөн зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ажилын хэсгийн ахлагч (Х.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ОТГОНЦОГТ

“Тэр бум мод” зөвлөгөөнийг
зохион байгуулах ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч

Х.Отгонжаргал
(Засаг даргын орлогч)

Ажлын хэсгийн нарийн бичиг

Г.Март
(Байгаль хамгаалагч)

Ажлын хэсгийн гишүүд

З.Амарсайхан
(Байгаль хамгаалагч)

Б.Буян-Өлзий
(ХАА-н тасгийн дарга)

Э.Зориг
(1-р багийн Засаг дарга)

Н.Мөнхзул
(2-р багийн Засаг дарга)

Г.Мөнхболд
(3-р багийн Засаг дарга)

Ж.Эрдэнэцогт
(ББСДОАДарга)

Д. Нэргүй
(Өргөн Сэлэнгэ ХХК)

Н.Цолмон
(Ойн хамт олон ГҮТББ-ийн захирал)

Г.Отгонбат
(Ивцэг ой БГБХН-ийн ойн инженер)

Б.Батсайхан
(Мишээл Ариун ХХК)

Д.Золзаяа
(Хярааны хонхор ХХК)

“Тэр бум мод” зөвөлгөөнийг зохион байгуулах
бэлтгэл ажлын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	хугацаа	Хариуцах эзэн
1	“Тэр бум мод” үндэсний зөвөлгөөний хүрээнд “Тэр бум мод” зөвөлгөөний төлөвлөгөөг боловсруулан батлуулах	4.22	Х.Отгонжаргал
2	“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөнд оролцох оролцогчийн нэрс гаргах	4.29	Ажлын хэсэг
3	Мод тарьж ургуулах, ойжуулалтын ажлыг олон жил үр бүтээлтэй хийсэн байгууллага, ойн сан гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, Аж ахуй нэгж, иргэнийг шагнаж урамшуулах	5.5	Х. Отгонжаргал Ж.Эрдэнэцогт
4	“Тэр бум мод” зөвөлгөөнд зарцуулагдах зардлын төсөв гаргах	4.25	Г.Март Б.Буян-Өлзий
5	Зөвөлгөөний хөтөлбөр боловсруулж батлуулах	4.26	Х.Отгонжаргал Г.Март
6	“Тэр бум мод” зөвөлгөөний хулдаасан хэвлэлийн эх бэлтгэл, хэвлүүлэх байршуулах	5.2	Ажлын хэсэг
7	Үр бордоо, тарьц суулгац, цэцгийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	5.5	Ж.Эрдэнэцогт Д.Нэргүй
8	“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн урилга, хөтөлбөр хэвлүүлэх	4.29	Ажлын хэсэг
9	Зөвөлгөөний нээлтийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	4.29	Г.Март
10	Оролцогчдыг бүртгэх	5.5	1,2,3 дугаар багийн Засаг дарга нар
11	Зөвөлгөөнд оролцогчдын цайны завсарлагын хүнс бэлтгэх, төсөв гаргах	4.25	Б.Батсайхан Д.Золзаяа
12	ЕБС-ийн сурагчдын дунд гар зургийн уралдаан, АХА тэмцээн зохион байгуулах ажлыг зохион байгуулах	5.3	Н.Цолмон Г.Отгонбат